

**БНХАУ-ЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ГЭР БҮЛИЙН БАЙР СУУРЬ,  
ТУЛГАМДСАН АСУУДЛУУД**

*Сарангоо  
МУИС-ийн ШУС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхим, докторант  
Я.Отгонбаяр  
МУИС-ийн ШУС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхим, дэд проф.  
Orcid: 0000-0001-7297-2288*

***Abstract:** This article examines the familial roles and decision-making power of female civil servants in the People's Republic of China from a sociological theoretical perspective. The research findings indicate that although women in China's civil service sector have made significant progress in their professional careers, they continue to face gender inequality in the distribution of family resources and decision-making authority. The study explores how social structures and policy environments influence this phenomenon, highlighting that traditional cultural norms and gender role allocations remain the primary obstacles to achieving equality.*

***Keywords:** female civil servants; family status; familial roles; role conflict;*

## **1. Удиртгал**

Олон улсын эрх зүйн баримт бичгүүд болох Хүний эрхийн түгээмэл тунхаглал (НҮБ, 1948), Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (НҮБ, 1976), Эмэгтэйчүүдийг алагчлах бүс хэлбэрийг устгах тухай конвенц (НҮБ, 1981) зэрэг бодлого тогтоомж БНХАУ-ын эмэгтэйчүүдийн нийгмийн байр суурь, тэр дундаа төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн нийгмийн байр суурь, гэр бүлийн байдалд чухал нөлөө үзүүлжээ. Үүний зэрэгцээ нийгэм, эдийн засаг, соёлын өөрчлөлтийн нөлөөгөөр жендэрийн тэгш эрхийн ойлголт түгээмэл болж БНХАУ-ын төрийн албан дахь эмэгтэйчүүдийн байр суурь улам дээшилж байна. Тус өгүүлэл нь БНХАУ-ын төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн гэр бүлийн дүр үүрэг (role), эрх, нөөцийн хүртээмж зэргийг тодруулж, эмэгтэйчүүдийн гэр бүлийн байр суурьд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар БНХАУ болон олон улсад хийсэн судалгааны материал, статистик мэдээлэл, хоёрдогч баримтад тулгуурлан шинжилсэн.

Сүүлийн хэдэн арван жилийн хугацаанд БНХАУ хурдацтай эдийн засгийн өсөлт, хотжилтыг туулж, ард иргэдийн амьдралын түвшин мэдэгдэхүйц дээшилсэн. Гэсэн хэдий ч жендэрийн тэгш бус байдал ажил эрхлэлт, төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн хувьд оршсон байна. 2018 оны "Global Gender Gap Report 2018" дурдсанаар, БНХАУ 149 орноос 103 дугаарт жагсаж, эдийн засгийн оролцоо, боловсролын түвшин, эрүүл мэнд ба улс төрийн эрх мэдэл зэрэг үзүүлэлтүүдэд жендэрийн ялгаа байсаар байна (World Economic Forum, 2018). Сүүлийн жилүүдэд БНХАУ-ын Статистикийн үндэсний газрын 2021 оны мэдээллээр, бакалавр болон мэргэжлийн боловсролын түвшинд суралцаж буй эмэгтэй оюутнуудын тоо 18.87 саяд, насанд хүрэгчдийн бакалаврын түвшинд суралцаж буй эмэгтэйчүүдийн тоо 5.64 саяд хүрч, эдгээр түвшинд эмэгтэй суралцагчдын эзлэх хувь тус тус 50.0% болон 56.0% байна. Эдгээр тоон үзүүлэлтүүд нь эмэгтэйчүүдийн дээд боловсрол эзэмших хувийн жин нэмэгдэж, боловсролын салбарт жендэрийн тэгш байдал ахиц дэвшил гаргаж буйг харуулж байна (БНХАУ-ын Засгийн газар, 2021). Харин 2022 оны байдлаар бакалаврын түвшний сургалтад элсэгчдийн 63%-ийг эмэгтэйчүүд эзэлж, анх удаа эрэгтэйчүүдээс давжээ. (Financial Times, 2022).

Хөдөлмөр эрхлэлтийн хувьд 2016 онд БНХАУ-ын хөдөлмөр эрхлэлтийн түвшин эрэгтэйчүүдийн хувьд 76.2%, эмэгтэйчүүдийн хувьд 60.4%, нийт хүн амын дунджаар 68% байсан. 2017 онд эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 76%, эмэгтэйчүүдийнх 59.8%, нийт хүн амын дунджаар 67.7% байв. 2018 онд эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 75.6%, эмэгтэйчүүдийнх 60.2%, нийт хүн амын дунджаар 67.7% байсан. 2019 онд эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 75.4%,

эмэгтэйчүүдийнх 61.1%, нийт хүн амын дунджаар 68% байв.2020 онд эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 75.4%, эмэгтэйчүүдийнх 61.2%, нийт хүн амын дунджаар 68.1% болсон Жэнь Шаосян (ZHANSHAOXIANG, 2021) .Энэнь эмэгтэйчүүдийн оролцоо Аажмаар нэмэгдэх болохыг харуулж байна. Ажилд зуучлах платформын мэдээллээр эмэгтэйчүүдийн дундаж сарын цалин 8,958 юань бөгөөд эрэгтэйчүүдийнхээс 13%-аар бага байна (Financial Times, 2024). Удирдах албан тушаалын хувьд өндөр албан тушаал хашиж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувь ердөө 17.5% байна (Wikipedia, 2024) . Гэр бүлийн хүрээнд уламжлалт үзэл хандлага нь эмэгтэйчүүдэд нөлөөлсөөр байгаа тул ажил мэргэжил болон гэр бүлийн үүргээ тэнцвэржүүлэхэд хүндрэлтэй хэвээр байна.

Бизнесийн хөгжлийн хувьд БНХАУ-ын бизнесийн орчин нь даяаршил болон нээлттэй бодлогын нөлөөгөөр ихээхэн өөрчлөгдсөн. Гэвч эмэгтэйчүүдийн бизнесийн салбар дахь оролцоо, нөлөө хангалттай түвшинд хүрээгүй байна (ZhangTao;PanQi, 2021).Хэдийгээр эмэгтэйчүүд боловсрол, ажил эрхлэлтээр ахиц гаргасан ч дээд түвшний удирдлагын болон шийдвэр гаргах албан тушаалд ажиллах хувь бага, цалингийн ялгаа байсаар байна. Энэ нь эмэгтэйчүүдийн бизнесийн салбар дахь өсөлтөд саад болж байна.

Хэдийгээр БНХАУ-ын эмэгтэйчүүд боловсрол, хөдөлмөр эрхлэлтээр ихээхэн ахиц гаргасан ч ажил мэргэжил, гэр бүлийн хүрээнд уламжлалт үзэл санаа болон жендэрийн тэгш бус байдлын нөлөөнд байсаар байна. Бизнесийн салбарт эмэгтэйчүүдийн оролцоо, нөлөөллийг нэмэгдүүлэх шаардлагатай бөгөөд жендэрийн тэгш байдлыг хангахын тулд илүү олон арга хэмжээ авах хэрэгтэй байна.

## 2. Судлагдсан байдал, онол-арга зүйн хүрээ

БНХАУ-ын нийгэм, эдийн засаг, соёл хурдан хөгжиж, эмэгтэйчүүдийн боловсролын түвшин өсөж, эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн түвшин өссөн нь гэр бүлийн эдийн засгийн чухал дэмжигч болж байна. Гэвч төрийн албан дахь эмэгтэйчүүдийн гэр бүлийн байр суурь, түүнээс улбаалах асуудлууд нь нийгмийн анхаарал татсан асуудал хэвээр байна. Үүний тухай маш олон эрдэмтэн судлаачид эмэгтэйчүүдийн гэр бүлийн байр суурь, ажил олголт, ажлын байрны дарамт зэрэг олон талаас судалгаа өрнүүлж, эмэгтэйчүүдийн нийгмийн байр суурь, гэр бүлийн байр суурийг дээшлүүлэх, эрэгтэй эмэгтэй эрх тэгш байх үзэл санааг сурталчилсаар иржээ. Сүүлийн жилд БНХАУ-ын төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн гэр бүлийн байдлыг судлах эрдэм шинжилгээний бүтээлүүд гарч буйг авч үзвэл байдалтай байна. Судлаач ЖуЮуХуа(ZHOUYUNHUA, 2015) нийгмийн давхраажилтын өнцгөөс БНХАУ-ын хотын эмэгтэйчүүд ажлын байр болон гэр бүлийн үүргээ хэрхэн зохицуулж байгаа талаар шинжилж, эмэгтэйчүүдийн ажил мэргэжлийн өсөлтөд тулгарч буй саад бэрхшээл болон түүнийг даван туулах арга замыг судалсан. Судлаач Ли Юньхуа олон тооны эмпирик судалгаанд үндэслэн БНХАУ-ын эмэгтэйчүүдийн мэргэжлийн хөгжилд тулгарч буй боломж болон сорилтуудыг шинжилсэн бөгөөд, ялангуяа удирдлагын дээд шат болон бизнесийн салбарт дэвшихэд тулгарч буй саад тогторуудыг онцлон авч үзсэн байна (LIYUNHUA,2023). Тэрээр БНХАУ-ын эмэгтэйчүүдийн эдийн засаг, боловсрол, ажил эрхлэлт, улс төрийн оролцоо, гэр бүлийн амьдрал зэрэг олон талын хамгийн сүүлийн үеийн судалгаа, судалгааны үр дүнг нэгтгэсэн бөгөөд БНХАУ-ын эмэгтэйчүүдийн нийгэм дэх байр суурийг судлах чухал эх сурвалж болж байна. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин, гэрийн ажил" (ДУЭХ, 2011/2021) <sup>1</sup>, Эмэгтэйчүүдийн ажил мэргэжлийн хөгжилд жирэмсний бодлогын тохируулгын нөлөө (Дуүхмтт, Гбтк, 2022) <sup>2</sup> гэх мэт одлогын судалгаа хийгджээ. Үүнээс гадна гадаад судалгааны үр дүн ч олон байдаг. Жишээ нь: судлаач Лю Юйцзе өндөр боловсролтой мэргэжлийн эмэгтэйчүүд асрагч ажиллуулах гэх мэт гэрийн ажлыг аутсорсинг хийх замаар дүр-үүргийн зөрчлийг хэрхэн бууруулж байгааг судалжээ (LIUYUJIE, 2019).

<sup>1</sup> ДУЭХ-Дундад улсын эмэгтэйчүүдын холбоо

<sup>2</sup> Дуүхмтт, Гбтк-Дундад улсын үндэсний хүн амын төлөвлөгөөт төрөлт, гэр бүл төлөвлөлтийн комисс

Дэлхий дахинаа авч үзвэл судлаач Рофел Лиза БНХАУ-ын төрийн албан дах эмэгтэйчүүд зах зээлийн эдийн засагт гэр бүлийн эрх мэдлийг хэрхэн дахин хэлэлцэж байгааг шинжилжээ (Rofel Lisa, 2020). Эмэгтэйчүүдийн эдийн засгийн байдал сайжирч, ажлын байран дахь субъектив сайн сайхан байдал буурах парадокс илэрч байна. Монгол улсад жэндэрийн асуудлыг хөндсөн олон судалгааг хөгжлийн байгууллагын дэмжлэгтэйгээр судлаачид гүйцэтгэж байна (С.Түмэндэлгэр, 2024). Үүнээс гадна төрийн захиргааны албан хаагчдын ажлын байрны бэлгийн дарамтын мэдгэг, хандлага болон тархалтын байдал сэдэвт судалгааг 2023 онд С.Түмэндэлгэр, Т.Бүрэнжаргал, Ц.Одгэрэл нарын судлаачид хамтран хийсэн бөгөөд тус судалгаанд төрийн албан хаагчдын бэлгийн дарамтын талаарх мэдлэг, хандлага, зан үйлийг судалсан байна (Т.Бүрэнжаргал ба бусад, 2024). Монгол улс дахь улс төрийн хүрэн дэх жэндэрийн эрх тэгш байдал: тулгамдаж буй асуудал ба шийдэл (М.Батбаатарбабусад, 2024) судалгааг М.Батбаатар нарын судлаачид хийжээ. Эдгээр эрдэм шинжилгээний ажил, баримт бичгүүд нь адил бус өнцөг, түвшний БНХАУ-ын эмэгтэйчүүдийн гэр бүлийн статусыг судалж, ажлын байр, гэр бүлд тулгарч буй бэрхшээлийг илрүүлэн, холбогдох арга хэмжэний саналыг дэвшүүлэв. Эдгээр судалгаа нь социологийн салбар дахь мэдлэгийн системийг баяжуулахаас гадна жэндэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжихэд чухал эрдэм шинжилгээний эх сурвалж болж байна.

Тус өгүүллийг "БНХАУ-ын эмэгтэйчүүдийн нийгмийн статусын судалгаа (III / IV үе шат) тайлан" зэрэг Тоо бүртгэлд үндэслэн, Улсын статистикийн агентлагийн судалгаа, "БНХАУ-ын эмэгтэйчүүдийн нийгмийн байр суурийн дөрөв дахь үеийн судалгаа (2020 оны 7-р сарын 1-ний өдөр)" зэрэг эрх бүхий мэдээллийн эх үүсвэрүүд болон холбогдох судалгааны нийтлэл, тайлан зэргээс эшлэн бичив. Эдгээр өгөгдөл нь төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн гэр бүлийн байр суурь ба тулгамдсан асуудлуудыг илүү нарийвчлан тодруулахад шаардлагатай баримтыг нотлон харуулах юм.

*Эмэгтэйчүүдийн гэр бүлийн дүр-үүргийг социологийн онолын үүднээс авч үзвэл :*

Эмэгтэйчүүдийн гэр бүлийн дүүргийг жендэр (Gender) хэмээх ойлголтын үүднээс харна. Жендэр (Gender) гэдэг нь эрэгтэй, эмэгтэй, охид, хөвгүүдийн харилцаанд илэрхийлэгдэх нийгмийн бүтэц, соёлын хэм хэмжээ, эзэмшсэн шинж чанаруудыг хэлнэ. Энэ нь цаг хугацаа, орон зай, хүрээлэн буй орчны өөрчлөлт болон эрх мэдэл, улс төрийн харилцааны нөлөөгөөр тасралтгүй хувьсан өөрчлөгдөж байдаг (Сэнгэдоржийн Түмэндэлгэр, 2019). Социологийн онолын талаар авч үзэхдээ юуны түрүүнд марксистуудын тайлбар чухал нөлөөтэй. Марксизм нь социологийн онолын хандлагын нэг. К.Маркс, Ф.Энгельс нар "жендэр" гэдэг ашиглаагүй ч, жэндэрийн эрх тэгш байдлын асуудалд онцгойлон анхаарсан. Хэн баялгийн өмчилж байгаа нь ноёрхогч, мөлжигч анги болдог гэсэн К.Марксын үзэл санааг Ф.Энгельс гэр бүлийн харилцаанд хөрвүүлэн ашигласан (Lindsey, 2005).

Зөрчилдөөний онолынхон нийгмийн бүтцийн нөлөөгөөр нэг хэсэг нь өөрсдийн ашиг сонирхлоо хэрэгжүүлж чадах давуу нөхцөлд амьдрахад хүргэдэг, нөөцийгийг хэн эзэмшиж байгаагаас хамаарсан зонхилгогч ба цөөнх гэсэн хэсэгт нийгэм хуваагддаг хэмээн үзнэ (С.Түмэндэлгэр, 2019). Ф.Энгельсийн адилаар эмэгтэй ХҮН хелстэй хөдөлмөр эрхлэх замаар эдийн засгийн хувьд хүчирхэгжиж байж, гэр бүлдээ эрх тэгш байдлыг тогтоож чадна гэж тайлбарладаг (Lindsey, 2005).

Гэхдээ бусад онолын зүгээс марксистууд, зөрчилдөөний онолыг дараах үндэслэлээр шүүмжилдэг. Үүнд:

- Эхнэр, нөхөр хоорондын үүргийн зохист уялдаа холбоог анхааралгүй, зөвхөн зөрчил, өрсөлдөөнд хүргэж байгаа талыг нь онцгойлон хардаг.
- Гэр бүл дэх хосуудын зөрчил нь зөвхөн эдийн засгийн шалтгаантай биш, нэг нь орлоготой, нөгөө нь орлогогүй байгааг хэт дөвийлгөж байна.
- Цалинтай хөдөлмөр эрхэлснээр гэр бүл дэх эмэгтэй хүний үүргийг бууруулахгүй байх нь олонтоо.

Бүтэц чиг үүргийн онол ёсоор нийгэм бол өөр хоорондоо нягт уялдаа холбоотой хэсгүүдээс тогтох

бөгөөд тэдгээр дэд хэсгүүд нь нийгмийн тодорхой хэрэгцээг хангахад чиглэнэ. Нийгмийн бүтэц нь дэд хэсгүүд хоорондоо тэнцвэртэй бөгөөд тогтвортойгоор оршин байх нөхцөлийг бүрдүүлэхийн хамт үр ашигтай байх боломжийг олгодог. байхад бусад хэсэг нь өөр төрлийн хөдөлмөр хийснээр илүү үр ашигтай, бүтээмжтэй байна. Энэхүү шаардлага гэр бүлд мөн адил илрэх бөгөөд өөрөөр хэлбэл, гэр бүлийн бүхий л хэрэгцээ хангагдах нөхцөл бүрдэх учраас эхнэр, нөхөр нь хөдөлмөрөө хуваарилах нь үр ашигтай юм гэж үзнэ. Энэхүү онолын хандлагаар бол эхнэр, нөхрийн дүр үүргийн ялгаа нь ноёрхол, зөрчилд хүрэхээс илүү зохистой уялдаа холбоо бүхий байх, тогтвортойгоор орших үндсийг хангана гэж үзсэн (С.Түмэндэлгэр, 2019).

Эдгээр онолыг судалгаанд интеграци хийснээр БНХАУ-ын төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн гэр бүлийн байр суурийг илүү олон өнцгөөс, гүнзгийрүүлэн тайлбарлаж, тэднийг нийгмийн бүтэц, эдийн засаг, соёлын үнэт зүйлс, гэр бүлийн шийдвэр гаргалтын эрх болон хөдөлмөрийн хуваарь дахь эрх тэгш бус байдлыг арилгах бодлогыг боловсруулан дэмжих боломжийг бүрэн авч үзэх болно.

### **3. Дундад улсын төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн гэр бүлийн байр суурийн бодит байдал, тулгамдсан асуудал**

#### **Гэр бүлийн шийдвэр гаргах эрх**

Хууль эрхзүйн түвшинд эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эрх эдэлдэг ч бодит амьдралд дундад улсын төрийн албан хаагч эмэгтэйчүүд гэр бүлийн шийдвэр гаргах эрхийн хувьд олон сорилттой тулгарсаар байна. Олон эмэгтэй хүн гэр бүлийн чухал шийдвэрүүд (орон сууц худалдан авах, машин худалдан авах, хүүхдийн боловсрол, гэр бүлийн санхүүгийн удирдлага гэх мэт) гаргахад бага оролцдог.

#### **А. Орон сууц худалдан авах шийдвэр**

2021 оны эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо нэмэгдсэн ч орон сууц худалдан авах шийдвэрт эрэгтэйчүүд давамгайлсан хэвээр байна. Судалгааны үр дүнгээс харахад, нийт өрхийн 60%-иас дээш хувьд орон сууц худалдан авах шийдвэрийг эрэгтэйчүүд гаргадаг бол эмэгтэйчүүдийн гаргасан шийдвэрийн хувь 40% орчим байдаг. Энэ хандлага нь төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн эдийн засгийн хараат бус байдал өсөж буйг харуулахын зэрэгцээ гэр бүлийн шийдвэр гаргах хэв маягийн өөрчлөлт болон нийгмийн үзэл хандлагын дэвшлийг илэрхийлж байна (CHFS мэдээллээр, 2021)<sup>3</sup>.

#### **Б. Машин худалдан авах шийдвэр**

Машин худалдан авах шийдвэр гаргахад мөн ижил хандлага ажиглагддаг. Дундад улсын Автомашины аж үйлдвэрийн холбооны 2019 оны дурдсанаар, өрхийн автомашин худалдан авах шийдвэрийн 70%-ийг эрэгтэйчүүд гаргадаг бөгөөд эмэгтэйчүүдийн оролцоо харьцангуй бага байдаг (АХЧХТ, 2019)<sup>4</sup>. Гэсэн хэдий ч, Эмэгтэйчүүд машин худалдан авах шийдвэрт улам бүр чухал үүрэг гүйцэтгэж байна, зарим тохиолдолд эрэгтэйчүүдийг давж гарах болжээ. Өөрөөр хэлбэл, эмэгтэйчүүдийн машин худалдан авахад зээл авах сонирхол эрэгтэйчүүдээс илүү өндөр байгааг харуулж байна. Автомашины санхүүжилтэд зээлийг нь хүлээн зөвшөөрөх түвшин эмэгтэйчүүдийн хувьд 60.3%, харин эрэгтэйчүүдийн хувьд 48.5% байна (www. 21jingji.com, 2024). Эдгээр өгөгдлүүд нь орчин үеийн машин хэрэглээнд эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах эрх, нөлөө өсөж байгаа бөгөөд зарим талаар эрэгтэйчүүдийг ч давж гарч байгааг харуулж байна.

<sup>3</sup> CHFS-China Household Finance Survey

<sup>4</sup> АХЧХТ—Автомашины хэрэглээний чиг хандлагын тайлан

## **В. Хүүхдийн боловсролын шийдвэр**

Хүүхдийн боловсролын хувьд эмэгтэйчүүд ихэвчлэн илүү их асран халамжлах үүрэг хүлээдэг боловч боловсролын шийдвэр (сургуулийн сонголт, нэмэлт сургалт гэх мэт)-ийг гаргахад эрэгтэйчүүд давамгайлдаг. Нийгмийн дэвшил, эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн үндсэн бодлогын хэрэгжилттэй холбоотойгоор, харилцан туслалцдаг, тэгш эрхтэй гэр бүлийн гишүүдийн харилцаа нь нийгмийн гол чиг хандлага болж, хосуудын хамтдаа гэр бүлийн шийдвэр гаргахад оролцох байдал тодорхой нэмэгдсэн хэдий ч, гэр бүлийн үнэлгээгүй үүргүүдийг гүйцэтгэх, тухайлбал гэрийн ажлын хуваарилалт, гэр бүлийн боловсролын чиглэлээр эмэгтэйчүүдийн гол үүрэг хэвээр байсаар байна (<https://ishare.ifeng.com>, 2023).

Эмэгтэйчүүд голчлон хүүхдийнхээ сэтгэхүй, зан чанар, оюун ухаан, мэдлэг зэрэг талуудыг хөгжүүлэх үүрэг хүлээдэг бөгөөд үүнд хичээлээс гадуурх үйл ажиллагааны сонирхлын бүлэг сонгох, ирээдүйн хөгжлийн төлөвлөлт зэрэг орно. Түүнчлэн 0-17 насны хүүхдийн даалгавар хийхэд ээжүүд голчлон оролцдог бөгөөд энэ нь 67.5% -тай байна. Харин аавууд гэрийн ажлын хуваарилалтад харьцангуй бага оролцдог. Зарим гэр бүлд эцэг, эх хоёр хамтран хүүхдээ халамжилдаг гэр бүлүүдийн тоо 7.5% -тай, харин хамтран боловсролын үйл ажиллагаанд оролцдог гэр бүлийн тоо 11.7% -тай байна. Энэ нь эрэгтэйчүүдийн боловсролын шийдвэр гаргахад оролцох байдал хязгаарлагдмал байгааг илтгэж байна (<https://ishare.ifeng.com>, 2023).

## **Г. Гэр бүлийн санхүүгийн шийдвэр**

Хөрөнгө оруулалт, хуримтлал зэрэг гэр бүлийн санхүүгийн асуудалд мөн эрэгтэйчүүд давамгайлсан байр суурь эзэлдэг. Гэр бүлийн санхүүгийн шийдвэрийг эрэгтэйчүүд гаргадаг байдал 65%-д бол эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах эрх ердөө 25%-д илэрсэн байна (Ардын Их Сургууль, 2022). Эдгээр тоон үзүүлэлтүүдээс харахад, дундад улсын төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн эдийн засгийн хараат бус байдал нэмэгдэж байгаа хэдий ч гэр бүлийн шийдвэр гаргахад тэдэнд бэрхшээлтэй хэвээр байна. Энэхүү үзэгдэл нь уламжлалт соёл, нийгмийн бүтэц, гэр бүлийн эдийн засгийн байдал болон хосуудын боловсролын түвшин зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр үүсдэг. Уламжлалт бүтцийн хувьд эрэгтэй хүнийг гэр бүлийн тэргүүн, шийдвэрийг голчлон гаргах эрхтэй байх ёстой гэж үздэг бол эмэгтэйчүүдийг дэмжигчийн үүрэг гүйцэтгэгч хэмээн хүлээн зөвшөөрдөг. Мөн гэр бүлийн эдийн засгийн байдал шийдвэр гаргах эрхийн хуваарилалтад нөлөөлдөг. Эдийн засгийн хувьд тогтворгүй гэр бүлд эрэгтэйчүүд ихэвчлэн илүү их хариуцлага хүлээж, шийдвэр гаргах эрхтэй байдаг бол санхүүгийн хувьд илүү сайн нөхцөлтэй гэр бүлд эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах оролцоо нэмэгдэх магадлалтай нь ажиглагдаж байна.

## **Гэр бүлийн хөдөлмөрийн хуваарилалт**

БНХАУ-ын төрийн албан хаагч эмэгтэйчүүд гэр бүлийн ажлууд болон хүүхэд асрах үүргийг ихэвчлэн хариуцдаг. Олон эмэгтэйчүүд ажил дээрээ амжилттай ажилладаг боловч гэртээ харьмагц гэр ахуйн ажлууд болон хүүхэд асрах үүрэг хүлээсээр байдаг. БНХАУ-ын Үндэсний статистикийн газрын 2018 оны үндэсний цаг ашиглалтын судалгаагаар эмэгтэйчүүд өдөрт дунджаар 3 цаг 48 минутыг төлбөргүй хөдөлмөрт (гэрийн ажил, гэр бүлийн гишүүдийг асрах зэрэг) зарцуулдаг бол эрэгтэйчүүдийн хувьд энэ хугацаа ердөө 1 цаг 32 минут байна.

Мөн Делойтте (Deloitte)-ийн 2021 оны "Ажил эрхэлж буй эмэгтэйчүүдийн дэлхийн төлөв" судалгааны тайланд дурдсанаар, Хятадын эмэгтэйчүүдийн 74% нь COVID-19 цар тахал дэгдсэнээс хойш ажлын ачаалал нь нэмэгдсэн гэж хариулсны зэрэгцээ 50% нь гэрийн ажлын ачаалал нь нэмэгдсэн гэжээ.

Эдгээр мэдээллээс харахад Хятадын эмэгтэйчүүд гэрийн ажил, хүүхэд асрах үүрэгт илүү их хариуцлага хүлээдэгтэй холбоотойгоор ажил болон гэр бүлийн үүргийн давхар ачаалал бүхий болох нь тодорхой байна.

Энэ үзэгдэл үе дамжин уламжлагдаж, нийгмийн соёлын нөлөөгөөр хадгалагдсаар ирсэн. Хятадын уламжлалт үзэл сурталд “эрэгтэйчүүд гадаа ажиллаж, эмэгтэйчүүд гэртээ байх ёстой” гэсэн үзэл санаа гүн гүнзгий суусан хэвээр байна. Эмэгтэйчүүд ажлын талбарт амжилт гаргасан ч гэр бүлийн доторх

үүрэг, хариуцлагын хуваарилалт үндсэндээ өөрчлөгдөөгүй хэвээр байгаа нь энэ асуудлыг улам хурцатгаж байна. Судалгаанууд мөн эрэгтэйчүүд өндөр орлоготой, удирдах албан тушаал хаших магадлал өндөр байдаг бол эмэгтэйчүүд цалин багатай, гүйцэтгэх түвшний ажил хийх хандлагатай байгааг харуулдаг. Энэхүү жендэрийн хэвшмэл ойлголт нь нийгэмд хүчтэй нөлөөлж, эмэгтэйчүүдийн гэр бүл болон ажил мэргэжил дэх үүрэг, оролцоог хязгаарласаар байна (Eagle, A.H & Wood, W, 2016). Ийнхүү давхар ачаалал бүхий байдал нь эмэгтэйчүүдийн мэргэжлийн хөгжилд сөргөөр нөлөөлөхөөс гадна амьдралын чанар болон аз жаргалыг нь бууруулах хүчин зүйл болж байна.

### **Гэр бүлийн харилцаан дахь эрх мэдлийн хуваарилалт**

БНХАУ-ын төрийн албан хаагч эмэгтэйчүүд гэр бүлд нөхөр, эхнэрийн харилцаа, хадам эцэг эх ба хүргэн, бэрийн харилцаа, үе дамжсан гэр бүлийн харилцаа зэрэг олон янзын бүтэц ажиглагддаг. Гэсэн хэдий ч, олон эмэгтэйчүүд гэр бүлийн харилцаанд харьцангуй сул байр суурь эзэлж, эрэгтэйчүүдтэй эрх тэгш бус нөхцөлд байдаг. Financial Times-ийн тайланд дурдсанаар, БНХАУ-д эмэгтэй их сургуулийн төгсөгчдийн тоо эрэгтэй төгсөгчдөөс илүү байгаа хэдий ч тэд хөдөлмөр эрхлэлт болон цалин хөлсний хувьд ноцтой сорилтуудтай тулгарсаар байна. Эмэгтэй төгсөгчид ажил хайхдаа эрэгтэйчүүдээс илүү хүндрэлтэй тулгардаг бөгөөд тэдний дундаж цалин эрэгтэйчүүдийнхээс 13%-иар бага байдаг. Үүнээс гадна, соёлын хүчин зүйлс болон төрийн төрөлт нэмэгдүүлэх бодлого нь ажил олгогчдыг эрэгтэй ажил горилогчдыг илүүд үзэхэд хүргэж, улмаар хөдөлмөрийн зах зээл дэх хүйсийн тэгш бус байдлыг улам даамжруулж байна (Financial Times, 2024). Энэ үзэгдэл нь уламжлалт соёлын үзэл баримтлал, гэр бүлийн эдийн засгийн байдал болон хосуудын боловсролын түвшний нөлөөгөөр үүсдэг. Уламжлалт хандлагаар эрэгтэй хүн гэр бүлийн тэргүүн байх ёстой гэж үзэж, илүү их эрх мэдэл эдлэх боломжтой байдаг бол эмэгтэйчүүдийг дагалдагч гэж үзэх хандлага хэвээр байна. Мөн нөхөр, эхнэрийн боловсролын түвшний ялгаа нь эрх мэдлийн хуваарилалтад нөлөөлдөг. Өндөр боловсролтой эмэгтэйчүүд гэр бүлдээ илүү их шийдвэр гаргах эрх эдэлдэг бол боловсролын түвшин бага эмэгтэйчүүд нөхрийн хяналт, дарамтад өртөх магадлал өндөр байдаг.

#### ***Хүйсийн ялгаварлал ба хэвшмэл ойлголт***

Хэдийгээр хуулиар эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрх тэгш байдлыг баталгаажуулсан ч бодит амьдрал дээр хүйсийн ялгаварлал болон хэвшмэл ойлголт түгээмэл оршсоор байна. Ажил мэргэжлийн орчинд эмэгтэйчүүд цалин хөлсний зөрүү, тушаал ахихад хүндрэлтэй тулгардаг бол гэр бүлийн орчинд илүү их гэрийн ажил, хүүхэд асрах үүрэг хүлээдэг. Энэ төрлийн тэгш бус байдал нь эмэгтэйчүүдийн гэр бүлийн байр суурийн доогуур байдал хийгээд мэргэжлийн хөгжил болон хувь хүний өсөлтөд саад учруулдаг. Хүйсийн ялгаварлал ба хэвшмэл ойлголт нь уламжлалт соёл дахь хүйсийн үүргийн талаарх ойлголтоос үүдэлтэй. Олон хүн эрэгтэйчүүдийг нийгмийн хариуцлагыг илүү их хүлээх ёстой гэж үздэг бол эмэгтэйчүүдийг гэр бүлийн үүрэг хариуцлагыг илүү их хүлээх ёстой гэж боддог (С. Түмэндэлгэр, 2024) хэвээр байна.

БНХАУ-ын төрийн албан хаагч эмэгтэйчүүд гэр бүл болон ажил мэргэжлийн хосолсон дарамттай тулгарч байна.

- Нэг талаас, тэд ажил мэргэжлийн хүрээнд амжилт гаргах, тушаал дэвшихийн төлөө хичээдэг.
- Нөгөө талаас, тэд гэр бүлийн үүргээ биелүүлэх, хүүхдээ өсгөх, эцэг эхээ асрах зэрэгт анхаарал хандуулах ёстой.

Энэ зөрчил нь эмэгтэйчүүдийн ажил мэргэжлийн хөгжлийг хязгаарлаж, амьдралын чанарыг нь бууруулдаг.

#### ***Ажил мэргэжлийн байр суурь ба албан тушаал ахих боломж***

Төрийн албан хаагч эмэгтэйчүүд албан тушаал ахих явцдаа тодорхой хэмжээний хүйсийн ялгаварлалтай тулгарсаар байгаа бөгөөд энэ нь тэдний гэр бүлийн байр сууринд шууд нөлөөлдөг. төрийн албан хаагчдын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 40.4% байгаа боловч удирдах албан тушаалд эрэгтэйчүүд давамгайлдаг. Жишээлбэл, орон нутгийн удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувь ердөө 16.7% байна (тайлан, 2022). Судлаач Чэнь Аймэй (2021) “Эмэгтэйчүүдийн ажил мэргэжлийн хөгжил ба гэр бүлийн эрх мэдлийн харилцаа” судалгаандаа өндөр албан тушаал хашиж буй эмэгтэйчүүд гэр бүлийн санхүү, хүүхдийн боловсрол, гэр бүлийн асуудал зэрэгт илүү их шийдвэр

гаргах эрх эдэлдэг болохыг тэмдэглэсэн. Харин тушаал дэвших боломж хязгаарлагдмал эмэгтэйчүүдийн хувьд гэр бүлийн эрх мэдлийн бүтэц дэх байр суурь харьцангуй сул байдаг. Нөгөө талаас гэр бүлийн үүргийн ачаалал нь ажил мэргэжлийн байр суурьт сөргөөр нөлөөлдөг тул ийнхүү хоёр талын нөлөөлөлтэй аж.

### **Эдийн засгийн хувь нэмэр ба гэр бүлийн байр суурийн уялдаа**

Олон эмэгтэйчүүд санхүүгийн хувьд хараат бус болж буй хэдий ч гэр бүлийн санхүүгийн шийдвэр гаргах түвшинд эрэгтэйчүүд давамгайлсан хэвээр байна. хоёр орлоготой гэр бүлд эмэгтэйчүүдийн орлого эрэгтэйчүүдээс өндөр байсан ч 57.8% нь гэр бүлийн санхүүгийн шийдвэрийг эрэгтэй хүн гаргасан бол эмэгтэйчүүдийн шийдэх хувь ердөө 29.3% байсан байна. Гэхдээ төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн орлогын түвшин өндөр байх тусам гэр бүлийн эрх мэдэл нь нэмэгддэг болохыг судалгаанууд харуулдаг (CFPS, 2022). Тянь Шяохун (2020) “Мэргэжлийн эмэгтэйчүүдийн эдийн засгийн хувь нэмэр ба гэр бүлийн шийдвэр гаргах эрх мэдэл” судалгаандаа 8,000 гаруй гэр бүлийн өгөгдлийг шинжилж, хэрэв эмэгтэйчүүдийн орлого гэр бүлийн нийт орлогын 50%-иас их байвал гэр бүлийн шийдвэр гаргах тэгш байдал эрс нэмэгддэг болохыг тогтоожээ. Харин эмэгтэйчүүдийн орлого эрэгтэйчүүдээс 30%-иар бага байх тохиолдолд, тэдний шийдвэр гаргах эрх мэдэл эрс буурдаг байна. Марксистуудын үзсэн өрх гэр бүл дэх эмэгтэйчүүдийн байр суурь тэдний эдийн засгийн байр сууриас хамааралтайг энэхүү баримт нотолж байна.

### ***Нийгмийн дэмжлэгийн тогтолцооны дутагдал***

БНХАУ-ын төрийн албан хаагч эмэгтэйчүүд, гэр бүлд шаардлагатай нийгмийн дэмжлэг дутмаг байдаг нь ноцтой асуудал болоод байна. Олон эмэгтэйчүүд гэр бүлийн асуудалтай тулгарах үедээ сэтгэлзүйн зөвлөгөө, хууль эрх зүйн туслалцаа зэрэг мэргэжлийн дэмжлэг авахад хүндрэлтэй байдаг. Судалгаанууд харуулж буйгаар, **нийгмийн дэмжлэгийн тогтолцооны дутагдал** нь эмэгтэйчүүдийг гэр бүлийн хүрээнд сул байр суурьтай байх гол шалтгаануудын нэг болж байна. Одоогийн байдлаар, БНХАУ-ын эмэгтэйчүүдэд чиглэсэн гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах үйлчилгээ, төв, тусламж дэмжлэгийн систем, нийгмийн үйлчилгээ хангалтгүй хэвээр байна.

### **Дүгнэлт**

- БНХАУ-д төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн гэр бүлийн статусын талаар мэдэгдэхүйц ахиц давшил гаргасан. Үүнд уламжлалт соёлын үзэл баримтлал, жендэрийн үүргийн хуваарилалт, нийгэм-эдийн засгийн байр суурьт гарсан өөрчлөлт зэрэг багтана.
- Хууль эрх зүйн хувьд эрэгтэй, эмэгтэй хүмүүс эрх тэгш боловч гэр бүлийн шийдвэр гаргалт, гэрийн ажил, гэр бүлийн эрх мэдлийн бүтцийн хувьд эмэгтэйчүүд олон саад бэрхшээлтэй тулгарсаар байна. Жендэрийн ялгаварлан гадуурхалт, өрөөсгөл ойлголт, гэр бүлийн үүрэг ба ажил мэргэжлийн үүргийн зөрчилдөөн, нийгмийн дэмжлэгийн тогтолцооны дутагдал нь төрийн албан хаагч эмэгтэйчүүдэд хүндрэл бэрхшээл болсон хэвээр байна.
- Ажлын болон гэр бүлийн үүргийн зөрчилдөөн эмэгтэйчүүдийн албан тушаал дэвших боломжийг бууруулж, төрсний дараа ажил мэргэжлийн өсөлтөд нь саад болж байна.
- Гэр бүл дэх эмэгтэйчүүдийн эдийн засгийн хувь нэмэр нь гэр бүлийн хүрээнд эмэгтэйчүүдийн байр сууринд нөлөөлдөг бөгөөд орлого өндөр байх тусам шийдвэр гаргах эрх мэдэл нэмэгддэг байна.

Ерөнхийдөө, ажил эрхэлдэг эмэгтэйчүүдийн эдийн засгийн бие даасан байдал, ажил мэргэжлийн өсөлт ахицтай байгаа хэдий ч гэр бүлийн хүрээнд жендерийн тэгш бус байдал оршин хэвээр байна. Ирээдүйд нийгмийн дэмжлэгийг нэмэгдүүлж, жендерийн тэгш байдлыг дэмжих бодлогыг хэрэгжүүлснээр эмэгтэйчүүдийн гэр бүлийн байр суурийг сайжруулж, бодит жендерийн тэгш эрхийг хангах юм.

## Ном зүй

- Ардын Их Сургууль. (2022). Гэр бүлийн санхүүгийн шийдвэр гаргалт дахь хүйсийн ялгаатай байдлын талаарх тодорхой судалгаа.
- АХЧХТ. (2019). Тайлан. <http://www.caam.org.cn/>.
- БНХАУ-ын Засгийн газар. (2021). Дундад улсын эмэгтэйчүүдийн хөгжил (2021-2030).
- Wikipedia. (2024.11.2).
- БНХАУ, ҮСГ. (2022). Хүн амын судалгаа. Бээжин хот
- Дундад улсын Эмэгтэйчүүдийн Холбоо. (2011/2021). Судалгааны тайлан. Бээжин хот
- ДУЭХ. (2011/2021). Дундад улсын эмэгтэйчүүдийн тоо бүртгэлийн судалгаа.
- ДУЭХ, Статистикийн хэлтэс. .
- Ли Инхэ. (2005). Эмэгтэйчүүдийн эрх мэдлийн давшил. Бээжин хот.
- НҮБ. (1948). Хүний эрхийн түгээмэл тунхаг. Нэгдсэн үндэстний байгууллагын ерөнхий Ассамблей.
- НҮБ. (1981). Эмэгтэйчүүдийг алагчлах бүс хэлбэрийг устгах тусай конвенц Нэгдсэн үндэстний байгууллагын Ерөнхий Ассамблей.
- С.Түмэндэлгэр. (2024). Жэндэрийн хэвшмэл үзэл:эрхийх хөдөлмөрийн хуваарь,улс төрийн үйл ажиллагаа,манлайлал. СОЦИОЛОГИ, 126 дугаар тал
- С.Түмэндэлгэр. (2019). ЖЭНДЭР БА НИЙГЭМ. Улаанбаатар хот
- Т.Бүрэнжаргал, С.Түмэндэлгэр, Ц.Одгэрэл (2024). Төрийн захиргааны албан хаагчдын ажлын байрны бэлгийн дарамтын мэдлэг, хандлага. Социологи , 17-603.
- CHFS (2021). Дундад улсын гэр бүлийн санхүүгийн судалгааны мэдээлэл. Бээжин хот
- <https://ishare.ifeng.com>. (2023.4.22). Эмэгтэйчүүдийн цэнхэр ном: Эмэгтэйчүүдийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн оролцооны шинжилгээ".
- JIYULIU. (2019). Working Women in Urban China: A New Gendered Division of Labor?
- Lindsey. (2005). Gender Roles:Sociological Perspective.4th edition.pearson prentive Hall.
- Lindsey. (2005). Sociological Perspective.4th edition.pearson prentive Hall.
- LIUYULIE. (2019). Working Women in Urban China: A New Gendered Division of Labor.
- LIYUNHUA. (2023). Дундад улсын мэргэжлийн эмэгтэйчүүдийн хөгжлийн тайлан. Нийгмийн Шинжлэх Ухааны Номын Хэвлэлийн Газар.
- М.Батбаатар ба бусад.(2024). Монгол улс дахь улс төрийн хүрэн дэх жендэрийн эрх тэгш байдал: тулгамдаж буй асуудал Социологи, 117-125.
- Rofel Lisa. (2020). "Patriarchy Reconfigured: Women, Work, and Post-Socialist China.
- WANGNING. (2018). Эмэгтэйчүүд ба олон нийтийн хэрэг – Хятадын ажил эрхэлж буй эмэгтэйчүүдийн нийгмийн оролцооны судалгаа.
- World Economic Forum. (2018). Global Gender Gap Report 2018.
- [www.21jingji.com](http://www.21jingji.com). (2024.3.28). Дундад улсын эмэгтэйчүүдийн автомашины хэрэглээний чиг хандлага 2024.
- ZHOUYUNHUA. (2015). Хүйс ба нийгмийн давхраажилт – Дундад улсын хотын эмэгтэйчүүдийн ажил мэргэжил ба гэр бүл.